



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 10 сарын 16 өдөр

Дугаар 491

Улаанбаатар хот

Дуудлагын худалдааг дахин зохион байгуулах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 4.2, 4.4 дахь заалт, “Мэдээ тайлангийн маягт батлах тухай” 269 дүгээр тогтоолын 2, 3 дахь заалт, 2023 оны “Тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 467 дугаар тогтоолын 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Дулаан шарын гол” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 21,000,000.00 (хорин нэгэн сая) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий автомашины хоёр удаагийн нээлттэй дуудлагын худалдаанд оролцогч ирээгүй тул нээлттэй дуудлагын худалдааг дахин (3 дахь) зохион байгуулахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтаар шинэчлэн тогтоосугай.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, “Дулаан шарын гол” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал П.Баярцэцэг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Орон нутгийн өмчийн газраас төлөөлөгчийг оролцуулан үндсэн хөрөнгийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу зохион байгуулах;

2.2. Нээлттэй дуудлагын худалдаанаас олох орлогыг зохих журмын дагуу компанийн дансанд төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Тээврийн хэрэгслийг худалдсаны дараа улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж энэ тогтоолын биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримтын хамт 2025 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

132002390
22-r huraldaan.docx



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн
42/... дугаар тогтоолын хавсралт

"ДУЛААН ШАРЫН ГОЛ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Хөрөнгийн бүртгэлийн дугаар	Ашиглалтад орсон огноо	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Балансын үнэ, хуриитлагдсан элэгдэл (төгрөг)	ТӨБЗГ-ын 2024 оны 270 дугаар тогтоолоор тогтоосон худалдах доод үнэ (төгрөг)	Шинэчлэн тогтоосон доод үнэ (төгрөг)
1	Ниссан караван /микроавтобус/ маркийн, 08-29 ДАР улсын дугаартай, DWGE25000358 арлын дугаар	000140	2011-05-31	1	ш	21,000,000.00	2,500,000.00	1,250,000.00
Нийт дүн				1 (нэг)		21,000,000.00 (хорин нэгэн сая)	2,500,000.00 (хоёр сая таван зуун мянга)	1,250,000.00 (нэг сая хоёр зуун тавин мянга)